

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК

2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

№ ХТ 02/2022

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 05 дүгээр сарын 14-ний өдрийн 12.00 цагаас 12.50 цагын хооронд Google Meet joining info; Video call link: <https://meet.google.com/rkb-xhah-ept> програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, ирц 126,566,937 ширхэг буюу 80.17%-ийн саналын эрхтэй хувьцааг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөрт болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Субшид тек ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т. Золбоо, хувьцаа эзэмшигч Г. Дулмааг төлөөлж иргэн Б.Батхүү нар итгэмжлэлээр хуралд оролцов. Компанийн зүгээс цахим хурлыг бичлэг хийж хадгалав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлыг хурлын эхэнд хурлын дарга хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хурлыг нээв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв.Үүнд:

1. Компанийн зарласан хувьцаанаас 16,572,469 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдах, нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд дахин 1,949,129 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гаргах тухай;
2. Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг одоо компанийн хувьцааг эзэмшиж буй эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;
3. Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааны зах зээлийн үнэ тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай;
4. Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл батлах тухай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хөтөлбөрийн дагуу хурлыг нээж хурлаар хэлэлцэх дээр асуудлуудын талаар танилцуулахыг ТУЗ-ын гишүүн Б.Батхүүгээс хүсэв.

1-р хэлэлцэх асуудлаар:

Б.Батхүү: Компанийн үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор компанийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж, хуулийн дүгнэлт гаргуулж, бизнесийн үнэлгээ хийлгүүлсэн. Компанийн бизнес үнэлгээг хөрөнгийн үнэлгээний “Мөнх-Оргил трейд” ХХК нь 22,615,200,000 төгрөгөөр буюу 1 ширхэг хувьцааг 143.25 төгрөг байх боломжтой гэж үзсэн. Компани 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын ТУЗТ 11/2021 тоот болон ТУЗТ 02/2022 тоот тогтоолуудаар Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг баталж, уг төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх зорилгоор Компанийн зарласан энгийн хувьцаанаас нийт энгийн хувьцааны 9.5%-ийг буюу 16,572,469 ширхэг энгийн хувьцаа гаргаж 1,905,833,935 төгрөг гаргаж нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын эрэлтийн хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 1,949,129 ширхэг хүртэлх энгийн хувьцааг

2022 ОНЫ 05-Р САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



нэмж гаргахаар шийдвэрлэж, ТУЗ-ын 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн тогтоолоор нийтэд санал болгох энгийн хувьцааны нэг бүрийн үнийг 115 төгрөг байхаар тогтоож, тогтоосон үнийн аргаар олон нийтэд санал болгохоор шийдвэрлэж, зөвшөөрөл авахаар үнэт цаасны танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хандсан. Нэмж гаргасан хувьцааны мөнгөн хөрөнгөөр охин компани Эйс ассошиэйтс ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж зээлийн үйл ажиллагаа эрхлэх, үлдэх мөнгөн хөрөнгийг онлайн худалдааны Кларотрейд ХХК-ний хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар дараах байдлаар хувь эзэмшихээр төлөвлөсөн байсан. Гэтэл нэмж хувьцаа гаргахыг МХБ зөвшөөрөн бүртгэж авсан боловч, СЗХ-ны 2022 оны 04-р сарын 12-ны өдрийн албан бичгээр заавал Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэмж хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлүүл гэсэн албан бичиг ирүүлсэн.

	Хөрөнгө оруулах компанийн нэр болон зарцуулалт	Зарцуулах мөнгөн дүн	Хөрөнгө оруулахын өмнөх эзэмшлийн хувь	Хөрөнгө оруулсны дараах эзэмшлийн хувь	Хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа хугацаа
1.1	“Эйс ассошиэйтс ББСБ” ХХК	1,650.0	85.00%	94.90%	2022 оны 2-р улирал
1.2	“Кларо трейд” ХХК	139.8	-	44.79%	2022 оны 2-р улирал
Нийт I		1,789.8			
2.1	“Кларо трейд” ХХК	210.5	-	67.02%	2022 оны 2-р улирал
Нийт II		2,000.3			

Хувьцаа эзэмшигч Ц.Хуяг: Компанийн тухай хуульд заасаны дагуу Компанийн зарласан хувьцаанаас ТУЗ нэмж гаргаж болно биз дээ? Яагаад тийм бичиг СЗХ-оос ирэв?

Б.Батхүү: Уг нь тийм Хуулийн Батбаяр энд партнерс ХХН-иас дараах тодорхойлолтыг гаргаж өгсөн боловч СЗХ заавал хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцүүл гэсэн шаардлага тавьсан.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалтын дагуу өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхээр заасан байна. Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн”, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална” гэж заасан. Түүнчлэн Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт компанийн дүрэмд компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх болон компанийн дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйлийг тусгахаар заасан. Үнэт цаас гаргагч “Эрдэнэс Сольюшинс” ХК (“Компани”)–ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын №ХЭХ04/2020 тоот шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Компанийн дүрэм (“Дүрэм”)–ийг баталсан бөгөөд тус Дүрэмд компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, зарласан хувьцааг эргэлтэд гаргахыг Төлөөлөн удирдах зөвлөлд эрх олгож дараах байдлаар тусгаж баталсан байна. Үүнд:

- Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Компани нь нэг бүрийн 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 \арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч\ ширхэг зарласан энгийн хувьцааг хууль болон энэхүү дүрэмд заасан журмын дагуу гүйлгээнд гаргах эрхтэй байна. Зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна”;

2022 ОНЫ 05-Р САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



- Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт “ТУЗ нь Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9 дүгээр зүйлийн 9.10.12 дахь заалтад “компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах”.

Түүнчлэн Компанийн өмнөх нэрээр “Шимтлэг” ХК-ийн 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн №ЭХ08/2014 тоот “Компанийн зарласан хувьцааг эргэлтэд гаргах, гаргах эрхийг хэрэгжүүлэх тухай” шийдвэрээр компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргахыг төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрч, төлөөлөн удирдах зөвлөл бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах зөвшөөрлийг олгож шийдвэрлэсэн байна.

Иймд Компанийн эрх барих дээд байгууллага хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн №ЭХ08/2014 тоот шийдвэр болон хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар Компанийн Дүрмийг баталж Компанийн тухай хуулийн нэмж хувьцаа гаргах заалтыг хэрэгжүүлсэн байна.

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно”, 42 дугаар зүйлийн 41.2 дахь хэсэгт “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана”, 42.2 дахь хэсэгт “Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь гаргах үүрэгтэй”, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалтад “... төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Иймд “Эрдэнэс Сольюшинс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хурлын №ТУЗТ 11/2021 тоот тогтоолоор Компанийн зарласан хувьцааны тоонд багтаан зарласан хувьцаанаас нэмж энгийн хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн Компанийн тухай хууль болон Компанийн Дүрэмд нийцсэн гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй шийдвэр байна. гэсэн тодохойлоло гаргасан.

2-р хэлэлцэх асуудлаар:

Б.Батхүү: Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг одоо компанийн хувьцааг эзэмшиж буй эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж байгаа нь Компани стратегийн болон бусад хувьцаа эзэмшигчид тус компанийн хувьцаа эзэмшигч болгосоноор Компанийн өргөжин тэлэхэд ач холбогдолтой. Ингэснээр компанийн бүтээгдэхүүний борлуулт нэмэгдэнэ гэж үзсэн учраас ТУЗ энэ шийдвэрийг гаргасан байна.

3,4-р хэлэлцэх асуудлаар:

Б.Батхүү: Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааны зах зээлийн үнэ тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухайд Компани нэмж гаргаж буй энгийн хувьцааны үнийг 115 төгрөгөөр тогтоосон боловч Хорооны үнэт цаасны газар тодорхой хямдралтай хувьцаа гаргах үед хаалтын ханштай уялдуулж гарга гэсэн өнөөдрийн байдлаар манай компанийн хувьцааны ханш 76-120 төгрөгийн хооронд байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Хуяг: Үнэ ханш хэдэн төгрөгөөр тогтохоор байна. Сонгож авсан андеррайтерын компани юу гэсэн байр суурьтай байна?

2022 ОНЫ 05-Р САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



Б.Батхүү: Гүүдсек ҮЦК сонгосон байгаа. 12 аймагт салбартай 600 мянган харилцагчтай компани. Эднийх 115 төгрөг болно гэсэн. Тэгэхдээ одоо ярилцаж байгаад 108 төгрөгөөр тогтоох саналтай байгаа гэсэн. Энэ асуудлыг ТУЗ-д Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.6, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.7 дахь хэсэгийг харгалзан эрхээ өгөх саналыг энэ хурлаар хэлэцүүлж байгаа юм. Энэ үед компанийн үнэлгээ 19 тэрбумаар үнэлэгдэх болно. Нэмж гаргаж буй буй хувьцааны үнэ буурсан татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг Кларо трейд ХХК-д оруулах мөнгөн хөрөнгийг бууруулах байх. Үүнтэй холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл батлана.

Хурлын дарга Т.Золбоо: Хөтөлбөрийн дагуу хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой санал, асуулга явуулья.

Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья. Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санал аа өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу.

Тооллогын комиссын дарга Г. Төгөлдөр: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Үүнд хэлэлцэж буй 3 асуудлаар хувьцаа эзэмшигчид санал ирүүллээ. Өөр брокерийн компаниар дамжуулан ямар нэгэн саналын хуудас ирсэнгүй болно. Хуралд оролцож буй санал өгсөн саналын хуудсыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг саналтай саналын хуудас гарсангүй. Саналын хуудас дараах байдалтай байна. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн								Нийт	
		Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн		Хүчингүй болсон			
		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Компани 16,572,469 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдах, нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд дахин 1,949,129 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гаргах тухай	126,566,937	100%	-	-	-	-	-	-	126,566,937	100%
2	Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг одоо компанийн хувьцааг эзэмшиж буй эзэмшигчдэд тэргүүн ээлжид	126,566,937	100%	-	-	-	-	-	-	126,566,937	100%

2022 ОНЫ 05-Р САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



	худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай										
3	Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааны зах зээлийн үнэ тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай	126,566,937	100%	-	-	-	-	-	-	126,566,937	100%
4	Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл батлах тухай	126,566,937	100%	-	-	-	-	-	-	126,566,937	100%

Хурлын дарга Т.Золбоо: Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр хэлцэж буй асуудлуудыг дэмжсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлд ямар нэгэн санал байна уу.

Хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр саналгүй тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2022 ОНЫ 05-Р САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Компанийн зарласан хувьцаанаас 16,572,469 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдах, нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд дахин 1,949,129 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэв;
2. Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг одоо компанийн хувьцааг эзэмшиж буй эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэв;
3. Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааны зах зээлийн үнэ тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгов;
4. Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл батлав.

ХУРЛЫН ДАРГА



/Т.ЗОЛБОО/

2022 ОНЫ 05-Р САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГА

[Signature]

/Т. ЗОЛБОО/